



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН
ГАЗАР



2021 оны ХАГАС
ЖИЛИЙН ТАЙЛАН

2021 оны 07 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1.1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” батлагдсан. Тус төлөвлөгөөнд нийслэл хэрэгжүүлэхээр туссан арга хэмжээнээс нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт хамаарах 4 ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг тооцон ажиллаж байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тайланг хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, тайлан гаргах загвар хүснэгтийн дагуу нэгтгэн 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 1/33 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.

3.7.8. Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлж, корпорацийг шинээр байгуулна.

Биелэлт: Засгийн газрын шийдвэр гарсны дараа үйл ажиллагаа явагдаж эхэлнэ. /Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй./

4.2.4. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чадавхыг бэхжүүлж, төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, нөхцөлөөр хангана.

Биелэлт: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга удирдлагатай 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдөр уулзалт зохион байгуулж, салбарын эрх зүйн баримт бичиг болоод холбогдох бусад асуудлаар харилцан санал солилцож, цаашид хамтран ажиллахаар болсон. Мөн 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 1/2092 дугаартай албан бичгээр 4 асуудлаар санал хүргүүлсэн.

1. Нийслэлийн хэмжээнд өмчийн бүртгэлийн бие даасан мэдээллийн нэгдсэн санг бий болгох, төрийн өмчийн мэдээллийн нэгдсэн сантай уялдуулах, улмаар Сангийн яамны санхүүгийн тайлангийн E-balance системтэй холбох;

2. Нийслэлийн өмчит болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын менежментийг сайжруулах, алдагдлыг бууруулах, компанийн засаглалыг сайжруулах зэрэг асуудлаар туршлага солилцох,

3. Өмчийн харилцаатай холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, журамд өөрчлөлт оруулахад холбогдох ажлын хэсэгт хоёр байгууллагын төлөөллийг оруулж ажиллуулах;

4. Байгууллагын албан хаагчдыг өмчийн чиглэлээр мэргэшүүлэх, чадваржуулах, мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах; /Хэрэгжилт 10%/

4.4.10.3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагалдан гарах дүрэм журмыг боловсруулж батлуулна.

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

Биелэлт: Шинэчлэгдэн батлагдах Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төсөлд тусгах саналыг нэгтгэн боловсруулж, Төрийн Өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлсэн. /Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй./

4.4.10.4. Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын ажлыг зохион байгуулж, төрийн өмчид бүртгэлээр хяналт тавина.

Биелэлт: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай” 9 дүгээр тогтоол батлагдсан. Тус тогтоолын дагуу орон нутгийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын ажлыг 2021 онд зохион байгуулах тухай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А-1/2179 тоот албан бичгээр мэдэгдсэн.

Чиглэлийн дагуу Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газраас Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, харьяа 47 газар, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газар, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот 37 газарт тус тус албан бичиг хүргүүлж ажиллалаа. Уг албан бичгээр Коронавируст цар тахлын улмаас үүсээд байгаа нөхцөл байдалд тохируулан заасан хугацаанд чанартай хийж гүйцэтгэх бэлтгэл ажлыг хангах талаар зөвлөмжийг хүргүүлсэн. /Хэрэгжилт 10%/

1.2 Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр:

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд тусгах саналыг шаардлагын дагуу боловсруулан 4 арга хэмжээг бодлогын баримт бичигт тусгуулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

- Нийслэлийн хэмжээнд өмчийн бүртгэлийн бие даасан мэдээллийн санг бий болгоно.
- Нийслэлийн төсвөөс санхүүжиж буй орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон орон нутгийн өмчит хаалттай хувьцаат компанийн тоог бууруулна.
- Нийслэлийн өмчийг зах зээлийн бодит үнэлгээгээр иргэн, аж ахуй нэгжүүдэд түрээслүүлж, төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлнэ.
- Нийслэлийн өмчийн томоохон үл хөдлөх хөрөнгүүдийн зах зээлийн бодит үнэ цэнийг тогтоох ажлыг зохион байгуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

2.1. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт

Тайлант хугацаанд Монгол улсын Засгийн газрын тогтоол-3, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол-3, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол-1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол-23, Нийслэлийн Засаг даргын үндсэн үйл ажиллагаатай холбоотой захирамж -41, эрх шилжүүлсэн захирамж-82, захиалагчийн хяналт тавих тухай-4 захирамж, бусад 9 баримт бичгийг бүртгэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Дээд газрын шийдвэрийн хэрэгжилтийн байдал:

/заалтаар, хувиар/

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

НӨАУГ-т ирсэн Тогтоол шийдвэр	Нийт	Засгийн газрын тогтоол	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол	Нийслэлийн Иргэдийн Хурлын огтоол	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол	Нийслэлийн Засаг Даргын захирамж			
						Үндсэн үйл ажиллагааны	Захиалагчийн хяналт тавих	Эрх шилжүүлэх тухай	Цаг үеийн шинж чанартай
Хяналтад авсан нийт шийдвэрлэлтийн тоо	166	3	3	1	23	41	4	82	9
Бүрэн хэрэгжсэн	90-100%	3		1	23	41	2		9
Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	-		3				2	82	
Гүйцэтгэлийн хувь	100	100		100	100	100	100	-	100

Тогтоол шийдвэрийн биелэлтүүдийг нэгтгэн, дүн шинжилгээ хийлгэж удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, 2021.06.24-ний өдрийн албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын үндсэн үйл ажиллагаатай холбоотой захирамж 41, эрх шилжсэн ажлын- 201, Захиалагчийн хяналт тавих тухай-4 захирамжийн хэрэгжилтийг тус тус нэгтгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлсэн байна.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Lomitorimng программд Нийслэлийн Засаг даргын 19, НЗД-ын 2 удаагийн зөвлөлийн хурлын тэмдэглэлээр өгөгдсөн 8 үүрэг даалгаврын хэрэгжилтийг бүрэн тайлагнаж 92,2%-тай дүгнэгдсэн.

Нийслэлийн болон Байгууллагын шуурхай зөвлөгөөний үүрэг даалгаврын биелэлт

	Хурлын тоо	Үүрэг даагавар	Биелэлт
Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн	22 удаа	74	95%
Байгууллагын шуурхай зөвлөгөөн	26 удаа	213	75%

ГУРАВДУГААР БҮЛЭГ

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

3.1.1. Төсвийн ерөнхийлөн захирагчаас ерөнхий менежертэй байгуулсан хариуцлагын гэрээ, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчтай байгуулах 2021 оны хариуцлагын гэрээ, байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэлтэс нэгжийн саналыг авч ЗГХЭГ-ын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан аргачлал, загварын

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

дагуу боловсруулсан. Төлөвлөгөөний төсөлд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдээс санал авч, 3 зорилгын хүрээнд 36 арга хэмжээг төлөвлөж, газрын даргаар батлуулан ажиллаж байна.

3.1.2. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын 2021 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшний талаар:

Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын 2021 оны эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтын төслийг хянан, Нийслэлийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/369 дүгээр захирамжаар баталгаажуулсан болно.

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын орлого, зардал, ашиг алдагдал:

/мянган төгрөг/						
№	Үзүүлэлт	2019 оны гүйцэтгэл	2020 оны зорилт	2020 оны гүйцэтгэл	Өсөлт бууралт	Биелэлт хувиар
1	Нийт орлого	268,716,577.0	294,441,391.6	267,851,597.9	26,589,793.8	91.0
2	Нийт зардал	304,181,784.7	346,983,065.2	319,964,720.1	27,018,345.1	92.2
3	Нийт ашиг, алдагдал	-35,465,207.7	-52,541,673.5	-52,113,122.3	-428,551.3	99.2
4	ОНТНЗ	1.13	1.18	1.19	-0.02	101.37

2020 онд үйл ажиллагаа явуулсан 15 орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд нь нийт 267,9 тэрбум төгрөгийн орлого олж, 319,9 тэрбум төгрөгийн зардал гарган 52,1 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Дээрх дүнгээс харахад орлогын төлөвлөгөө 9 хувиар тасарч, зардал орлогын төлөвлөгөөний тасралттай холбоотойгоор 7,8 хувиар хэмнэгдэж, алдагдлын хэмжээ зорилтот түвшингээс 428,6 сая төгрөгөөр буюу 0,8 хувиар буурсан байна. /Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын нийт орлого зардал, ашиг алдагдлын судалгааг хавсралтаар харуулав./

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой 3 үйлдвэрийн газар нийт 492,8 сая төгрөгийн цэвэр ашигтай, 12 үйлдвэрийн газар нийт 52,1 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

Ашигтай ажилласан газруудыг дурдвал: Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар 405,5 сая, Хот төлөвлөлт, судалгааны институт 64,1 сая, Улаанбаатар зам засвар, арчлалтын газар 23,1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.

Үйлдвэрийн газруудаас хамгийн их алдагдалтай ажилласан:

- Ус сувгийн удирдах газар 27,2 тэрбум,
- Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар 11,9 тэрбум,
- Зорчигч тээврийн нэгтгэл 5,5 тэрбум,
- Геодези усны барилга байгууламжийн газар 3,9 тэрбум,
- Зорчигч тээвэр гурав 2,4 тэрбум алдагдалтай ажилласан байна.

5 байгууллага нийт алдагдлын 98,3 хувийг эзэлж байна.

Алдагдалд нөлөөлж буй томоохон хүчин зүйлийн нэг нь элэгдлийн зардал юм. Эргэлтийн хөрөнгө ихтэй томоохон үйлдвэрийн газрууд нь элэгдлийн зардлаар алдагдал хүлээж байна.

Мөн нийгэмд чиглэсэн үйлчилгээ эрхэлдэг үйлдвэрийн газруудын хувьд холбогдох хороодын үнэ тарифын зохицуулалттай холбоотой алдагдал хүлээх нэг шалтгаан болж байна.

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

3.1.3. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын захиралтай байгуулсан контрактын 2020 оны биелэлт дүгнэсэн талаар:

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны “Журам гэрээний үлгэрчилсэн загварыг шинэчлэн батлах тухай” 54 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай Контракт байгуулах, дүгнэх журам”-ын дагуу орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиралтай байгуулсан Контрактын биелэлтийг хэлэлцэн дүгнэлээ.

2020 онд 15 үйлдвэрийн газар үйл ажиллагаагаа хэвийн явуулж, 2 үйлдвэрийн газар нь менежментийн хувьчлалын жагсаалтад орсноор үйл ажиллагаа явуулаагүй тул дүгнэгдэх боломжгүй байна.

Контракт дүгнэсэн дүнг харуулбал:

Д/д	Үзүүлэлт	Контракт дүгнэсэн дүн
1	Бүрэн хангалттай	0
2	Хангалттай	6
3	Ажил сайжруулах шаардлагатай	9
4	Хангалтгүй	0
5	Үнэлгээ өгөөгүй	2
	Нийт	17

3.1.4. Нийслэлийн Өмчит үйлдвэрийн газар болон оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Удирдах зөвлөлд нийслэлийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх:

- НИТХТ-ийн 2021 оны 20, 22, 23, 24 дүгээр тогтоолоор Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК” ХХК, “Олон улсын худалдаа логистикын төв” ХК, “Улаанбаатар спорт менежмент” ХК, “Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК-ийн дүрэмд тус тус өөрчлөлт оруулсан.
- НИТХТ-ийн 2021 оны 18 дугаар тогтоолоор “Олон улсын худалдаа логистикын төв” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус 3 гишүүнийг томилсон.
- НИТХТ-ийн 2021 оны 19 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 3, хараат бус 3 гишүүнийг тус тус томилсон.
- НИТХТ-ийн 2021 оны 64 дүгээр тогтоолоор “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус 3 гишүүнийг томилсон.

3.2. Хөрөнгийн хөдөлгөөний талаар хийж хэрэгжүүлсэн ажил:

3.2.1. Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн ажлын талаар

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө, төсөл хөтөлбөр, гадаадын зээл, буцалтгүй тусламж, гадаад дотоодын хандив бэлэглэлээр нийслэлийн өмчид шинээр бий болсон **96,529.0 сая** төгрөгийн эд хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэж, эзэмшигч байгууллагын данс бүртгэлд тусгуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- | | |
|---|-----------------------------|
| 1. Барилга байгууламж 23 | 44, 293,6 сая төгрөг |
| 2. Тээврийн хэрэгсэл 102 | 13, 353,6 сая төгрөг |
| 3. ЭБХХК-ын хурлаар бүртгэсэн эд хөрөнгө: – | 1,874,6 сая төгрөг |
| 4. Шинээр бий болсон эд хөрөнгө: – | 37, 330,6 сая төгрөг |

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

Нэг. Барилга байгууламж – 23 нэрийн **44,293,6 сая төгрөг**

- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021.02.05-ны өдрийн 08 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2020.03.09-ний өдрийн А/145 дугаар захирамжаар улсын төсвийн хөрөнгө оруулалт, АХБ-ны хөнгөлөлттэй зээл, “Гүүд нейборс” Олон улсын байгууллагын хандив, дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Чингэлтэй, Хан-Уул, Багануур дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж ашиглалтад орсон нийт 8,681.2 сая төгрөгийн өртөг бүхий (ЧД-ийн 33-р цэцэрлэг, 280-р цэцэрлэг, ХУД-ийн Нэгдсэн эмнэлгийн давхрын өргөтгөл, БНД-ийн Гүн галуутай цогцолбор сургуулийн спорт заал, Хог ангилах төв, зөөврийн ус түгээх 2 байр) 7 барилга байгууламж,
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021.02.05-ны өдрийн 09 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын 2020.03.09-ний өдрийн А/144 дүгээр захирамжаар Баянгол, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт улсын төсвийн хөрөнгө оруулалт, төрийн өмчийн концессээр баригдаж ашиглалтад орсон нийт 21,042.3 сая төгрөгийн өртөг бүхий /БГД-ийн 73-р сургууль, СХД-ийн 143-р сургууль, 55, 269, 272 дугаар цэцэрлэг/ 5 барилга байгууламж,
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021.05.10-ны өдрийн 58 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2020.05.31-ний өдрийн А/399 дүгээр захирамжаар Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон нийт 10,187.2 сая төгрөгийн өртөг бүхий /48-р сургуулийн спорт заал, ШЭНТ-ийн барилга, Хот тохижилтын газрын автобааз, Түргэн тусламжийн төвийн Чингэлтэй дэх салбарын барилга, 90 үхрийн зогсоол бүхий иж бүрэн цогцолбор фермерийн аж ахуй барилга байгууламж, 67-р сургуулийн спорт заалны хүзүүвч, 273-р цэцэрлэгийн барилга/ 7 барилга байгууламж,
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021.06.18-ны өдрийн дугаар тогтоолоор Япон улсын буцалтгүй тусламжийн “Өвсний үндэс” хөтөлбөр, улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Налайх дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж ашиглалтад орсон нийт 4,382.9 сая төгрөгийн өртөгтэй /123-р цэцэрлэгийн өргөтгөл, 279-р цэцэрлэгийн барилга, НД-ийн Цагдаагийн хэлтсийн барилга, 8-р хорооны байр/ 4 барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэх буюу эзэмшигч байгууллагуудын данс бүртгэлд бүртгэх 4 тогтоол гаргуулж, тогтоолын дагуу эзэмшигч байгууллагуудад ашиглалт хамгаалалтыг хариуцуулах тухай холбогдох захирамжийг албажуулан тогтоол, захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг эзэмшигч байгууллагуудад албан бичгээр даалгасан.

Хоёр. Тээврийн хэрэгсэл – **13,353.6 сая төгрөг** /102 ш/

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/12 дугаар захирамжаар 389.0 сая төгрөгийн 7, А/13 дугаар захирамжаар 635.8 сая төгрөгийн 11, А/20 дугаар захирамжаар 3,276.6 сая төгрөгийн 13, А/21 дүгээр захирамжаар 662.4 сая төгрөгийн 7, А/22 дугаар захирамжаар 1,651.5 сая төгрөгийн 8, А/147 дугаар захирамжаар 1,209.9 сая төгрөгийн 13, А/154 дүгээр захирамжаар 2,324.0 сая төгрөгийн 7, А/329 дүгээр захирамжаар 539,1 сая төгрөгийн 9, А/384 дүгээр захирамжаар 2,385.7 сая төгрөгийн 23, А/430 дугаар захирамжаар 279,6 сая төгрөгийн 4, нийт 13,353.6 сая төгрөгийн үнэтэй 102 тээврийн хэрэгслийг нийслэлийн өмчид бүртгэх 10 захирамжийг гаргуулж, хэрэгжилтийг ханган ажилласан.

Гурав. ЭБХХХК-ын хурлаар шийдвэрээр бүртгэсэн эд хөрөнгө – **1,490.6 сая төгрөг**

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр, хандив бэлэглэлээр ирсэн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг үндсэн хөрөнгөндөө бүртгэх зөвшөөрөл хүссэн байгууллагуудын

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

хүсэлтийг “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын хурлаар хэлэлцүүлж, 32 байгууллагын 1,874.6 сая төгрөгийн эд хөрөнгийг бүртгэх Газрын даргын тушаал гаргасан.

Дөрөв. Шинээр бий болсон эд хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авах тухай албан бичиг хүргүүлсэн байдал –37 330,6 сая сая төгрөг

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар болон төсөл хэрэгжсэн байгууллагуудаас ирүүлсэн улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, нийслэл, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн их засвар, тохижилтын эд хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгүүлэх хүсэлтийг үндэслэн 182 төсөл арга хэмжээний үр дүнд шинээр бий болсон нийт 37,330.6 сая төгрөгийн эд хөрөнгийг данс бүртгэлдээ тусгаж, ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг даалгасан 119 албан бичгийг өмч эзэмшигч 74 байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн хөрөнгөөр шинээр бий болсон 1,096.3 сая төгрөгийн хөдлөх хөрөнгийг бүртгэн авсан 78 тушаалыг өмч эзэмшигч байгууллагуудаас ирүүлснийг хүлээн авч, холбогдох судалгаанд оруулав.

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, НОНХС, замын сангийн хөрөнгөөр 2021 онд санхүүжих хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай Нийслэлийн Засаг даргын 77 захирамжийг хүлээн авч **266,560.0 сая** төгрөгийн төсөвт өртөгтэй **456** төсөл арга хэмжээ бүхий судалгааг гаргасан. 2021 онд санхүүжих дүнгээр авч үзвэл:

- НТХО-аар хийгдэх – 9,082.8 сая төгрөгийн 71 ажил,
- Замын сангийн хөрөнгөөр хийгдэх – 16,599.2 сая төгрөгийн төгрөгийн 66 ажил,
- НОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих – 24,358.6 сая төгрөгийн 220 ажил,
- УТХО-аар хийгдэх 75,489.7 сая төгрөгийн 119 ажлын судалгааг гаргасан.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын дагуу ажилласан нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан, гадаадын буцалтгүй тусламжаар санхүүжигдсэн барилга байгууламж, тохижилтын ажлыг байнгын ашиглалтад оруулах 19 комиссын бүрэлдэхүүнд санал өгч, комиссын дүгнэлтийг баталгаажуулсан болно.

3.2.2. Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн талаар

А. Барилга байгууламж, тээврийн хэрэгсэл балансаас балансад шилжүүлэх

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 3 удаагийн тогтоолоор 9 байгууллагын нийт **1,144,5** сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг нийслэлийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэн байна.

- НИТХТ-ийн 2021 оны 27 дугаар тогтоолоор нийт 732,6 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий гал унтраах тусгай зориулалтын 6 тээврийн хэрэгсэл, 28,4 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, 17,7 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий гадна цахилгааны шугам,
- НИТХТ-ийн 2021 оны 47 дугаар тогтоолоор 4,8 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий тоног төхөөрөмж,
- НИТХТ-ийн 2021 оны 57 дугаар тогтоолоор 361 сая бүртгэлийн үнэ бүхий ой хээрийн түймэр унтраах тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл,

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 5 удаагийн тогтоолоор 6 байгууллагын нийт **41,764.6** сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгө:

- НИТХТ-ийн 2021 оны 11 дүгээр тогтоолоор 48,4 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 3 худгийн барилга,
- НИТХТ-ийн 2021 оны 11 дүгээр тогтоолоор 108,9 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий сургуулийн барилга,
- НИТХТ-ийн 2021 оны 43 дугаар тогтоолоор 212,4 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга байгууламж, тоног төхөөрөмж,
- НИТХТ-ийн 2021 оны 51 дүгээр тогтоолоор 41,339.3 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгө, холбогдох газар болон эд хөрөнгө,
- НИТХТ-ийн 2021 оны 60 дугаар тогтоолоор 212,9 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий халаалтын зуухны барилга, өргөтгөлийн барилгыг тус тус балансаас балансад шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийслэлийн Засаг даргын 8 удаагийн захирамжаар нийт 1,189.9 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 26 ширхэг тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлсэн байна.

3.2.3. Данснаас хассан хөрөнгийн талаар:

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4.2-т заасны дагуу Барилга байгууламжийн ашиглалтын болон байгалийн хүчин зүйлээс хамаарч үндсэн хийц бүтээцэд хэвийн хэмжээнээс илүү ан цав үүсэж, илт эвдрэл, гэмтэлтэй, үндсэн бүтээц хийцэд өөрчлөлт орсон нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр батлагдсан 2 байгууллагын нийт 53,0 сая төгрөгийн үнэ бүхий 2 барилга байгууламжийг нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тогтоолын төсөл боловсруулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох дарга нараас санал авч, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж хурлын тогтоолоор баталгаажуулан, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

- Сонгинохайрхан дүүргийн 74 дүгээр сургуулийн балансад бүртгэлтэй 24,6 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга
- “Сонгинохайрхан амралт цогцолборын газар” ОНӨТҮГ-ын балансад бүртгэлтэй 28,3 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга,

3.2.4. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын хурлыг зохион байгуулах:

Газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/89 дүгээр тушаалаар ЭБХХХК-ын үйл ажиллагааг ЗСХ хариуцан ажиллаж эхэлсэн. Тайланд хугацаанд “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын ажиллах журмын дагуу 7 удаа хурал зохион байгуулагдаж давхардсан тоогоор нийт 150 байгууллагын 10,866,841,768 төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгийн хөдөлгөөний асуудлыг хэлэлцүүлж, хурлаас гарсан шийдвэрийн дагуу боловсруулсан 131 тушаалын төсөлд хяналт тавьж, баталгаажуулсан.

а/ Шинээр худалдаж авах хөрөнгө: 6 байгууллагын 83,192,200 төгрөг

б/ Бүртгэх хөрөнгө: 32 байгууллагын 1,874,655,952 төгрөг


НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

в/ Балансаас балансад шилжүүлэх хөрөнгө: 17 байгууллагын 701,787,900 төгрөг
 г/ Данснаас дансанд шилжүүлэх хөрөнгө: 9 байгууллагын 1,061,577,434 төгр
 д/ Данснаас хасах хөрөнгө: 83 байгууллагын 7,105,900,603 төгрөг


ЭРТЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ХӨДӨЛГӨӨН ХАРИУЦСАН КОМИССЫН ТАЙЛАН (2-Р УЛИРАЛ)

Улирал	Байгууллагын	Хөрөнгө худалдан авах	Байгууллагын	Хөрөнгө бүртгэх	Байгууллагын	Балансаас балансад хөрөнгө шилжүүлэх	Байгууллагын	Данснаас дансанд хөрөнгө шилжүүлэх	Байгууллагын	Хөрөнгө данснаас хасах	Байгууллагын	Хөрөнгө дахин үнэлэх	Нийт байгууллагын тоо	Нийт хөрөнгийн дүн
1 дүгээр улирал	1	16,161,000	5	1,046,704,722	1	638,000	2	3,119,600	27	1,005,950,509	0	0	36	2,072,573,866
2 дугаар улирал	5	67,031,200	27	827,951,230	16	701,149,900	7	1,058,457,834	56	6,099,950,094	3	39,727,644	114	8,794,267,902
Нийт	6	83,192,200	32	1,874,655,952	17	701,787,900	9	1,061,577,434	83	7,105,900,603	3	39,727,644	150	10,866,841,768

ЭБХХХК-н 7 удаагийн хурлын хөрөнгийн хөдөлгөөний дүн /сар бүрээр/



ЭБХХХК-ын хурлын хөрөнгийн хөдөлгөөний нийт дүн /2020 оны эхний хагас жилийн байдлаар/



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

3.2.5. Нийслэлийн өмчийн мэдээллийн сангийн баяжилтын талаар:


Нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой 781 байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, хөрөнгийн хөдлөл өөрчлөлт, эд хөрөнгийн талаарх мэдээллийг тулган шалгаж, ТӨ болон ТӨХ 15 маягтын дагуу нэгтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлсэн.

Нийслэлийн өмч 2020 оны жилийн эцсийн балансаар нийт хөрөнгө 4,821,984.8 сая төгрөг, үүнээс:

- Эргэлтийн бус хөрөнгө 3,117,968.3 сая төгрөг,
- Эргэлтийн хөрөнгө 1,704,016.6 сая төгрөг байна.

Элэгдэл тооцоогүй дүнгээр буюу бүртгэлийн анхны үнээр авч үзвэл нийслэлийн өмчийн эргэлтийн бус хөрөнгө 4,847,909.3 сая төгрөг/

д/д	Хөрөнгийн төрөл	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
1	Байгууллагын тоо	733	758	770	772	781
2	Эргэлтийн хөрөнгө	157,060,821.90	506,704,524.7	603,807,014.5	933,821,035.4	1,704,016,600.0
3	Эргэлтийн бус хөрөнгө	1,217,054,990.90	1,581,182,482.7	3,219,405,800.1	3,176,392,780.5	3,117,968,300.1
4	Нийт хөрөнгө	1,374,115,812.8	2,087,887,007.5	3,823,212,814.6	4,110,213,815.9	4,821,984,810.1



3.2.6. Өмч хувьчлалын ажлын талаар:

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020.12.04-ний өдрийн 02/13 дугаар тогтоолоор 2021 онд нийслэлийн өмчөөс 8 объектыг хувьчлах жагсаалтыг баталсан боловч өмч хувьчлалаас нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний дүн, өмч хувьчлалын үйл ажиллагааны зардалд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг батлаагүй юм.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2003-2019 оны тогтоолуудаар хувьчлах эд хөрөнгийн жагсаалтад орсон боловч хувьчлагдаагүй 25 объект, барилга байгууламжийн талаар цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, Нийслэлийн Өмч хувьчлах комиссын хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхэд голлон анхаарч ажиллаж байна.

Нийслэлийн Өмч хувьчлах комиссын энэ оны эхний хурлыг зохион байгуулахаар 2021.01.19-ний өдөр 17 хэлэлцэх асуудал бүхий хурлын төлөвлөгөөний төсөл, холбогдох танилцуулгуудыг боловсруулж Газрын даргад танилцуулсан боловч өнөөдрийг хүртэл

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР


комиссын хурал хуралдаагүй, Нийслэлийн Засаг дарга хурлын цаг өгөөгүй байна. Хэлэлцэх асуудлуудыг танилцуулбал:

- Шинээр хувьчлах тухай - 1,
- Өмчлөгчийн эрх олгох тухай - 1,
- Хувьчлалын тайлан батлах тухай - 1,
- Дахин дуудлагын худалдаагаар хувьчлах тухай - 1,
- Цаашид авах арга хэмжээний талаарх саналыг танилцуулах - 13,

3.2.7. Барилга байгууламжийн дуудлага худалдааны талаар:

Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2020 оны 12, 25 дугаар тогтоолуудаар дуудлагын худалдааны анхны үнийг нь тогтоож, дуудлагын худалдааг нь зохион байгуулахыг манай газарт даалгасан “Монгол шуудан” ХК-ийн 26 дугаар салбарын түрээсээр эзэмшиж байсан байр, Багануур дүүргийн 2 дугаар хорооны хуучин барилгыг хувьчлах нээлттэй дуудлагын худалдааг 2021.04.22-ны өдөр зохион байгуулахаар 2021.03.22-ны өдрийн “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Үндэсний шуудан” сонинуудад зарыг нийлүүлсэн боловч цар тахалтай холбоотойгоор хойшилж, дуудлагын худалдааг 2021.05.13-ны өдөр зохион байгуулсан.

Багануур дүүргийн 2 дугаар хорооны хуучин барилгын дуудлагын худалдаанд оролцогчийн санал ирээгүй ба “Монгол шуудан” ХК-ийн 26 дугаар салбарын түрээсээр эзэмшиж байсан орон сууцны зориулалттай байрны дуудлагын худалдаанд 2 иргэн саналаа ирүүлэн оролцож, иргэн О.Тулгаа 85,1 сая төгрөгөөр хувьчилж авсан болно.



3.2.8. Тээврийн хэрэгслийн дуудлага худалдааны талаар:

Нийслэлийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/165 дугаар захирамжаар нийслэлийн өмчит зарим байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, техникийн комиссын актаар ашиглалтын шаардлага хангахгүй, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдсон тээврийн хэрэгслүүдийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах асуудлыг баталсан. Тус захирамжийн дагуу нийт 7 удаагийн авто машины дуудлага худалдааг зохион байгуулж 32 автомашиныг худалдан борлуулж 54,000,000 төгрөгийг төсөвт төвлөрүүлж ажиллалаа. Мөн сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 29 байгууллагын 1,426,120,516.6 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 50 ширхэг тээврийн хэрэгсэл татан төвлөрүүлсэн. Нийслэлийн төсөвт байгууллагуудаас ирүүлсэн тээврийн хэрэгсэл данснаас хасах хүсэлтийг судалж, газар дээр үзэж танилцан фото зургаар баталгаажуулан “Тээврийн хэрэгсэл данснаас

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

хасах тухай” Нийслэлийн Засаг даргын захирамжийн төсөл боловсруулан санал аваад байна.

3.3.1. Төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийн талаар:

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/10 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, зардлын хуваарийг сар, улирлаар гарган Санхүү төрийн сангийн хэлтсээр батлуулан мөрдөн ажиллаж байна.

Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 06 дугаар сарын 30-ны байдлаар хүснэгтээр харуулбал:

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	(- илүү, +д/туу)
1	Түрээсийн орлого	983,000.0	727,779.1	74%	255,220.9
2	Өмч хувьчлал	0.00	85,084.9	0%	-85,084.9
3	Ногдол ашиг	47,000.00	0.00	0%	47,000.00
4	Акталсан хөрөнгө борлуулсны орлого	0.00	79,467.1	0%	-79,467.1
ДҮН		1,030,000.0	892,331.1	86,6%	40,903.4

Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, зардлын хуваарийг сар, улирлаар гарган Санхүү төрийн сангийн хэлтсээр батлуулан мөрдөн, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 01-ний дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст мэдээ тайланг хүргүүлэн, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

3.3.2. Төсвийн ил тод байдлын талаар:

Монгол Улсын Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор тус тус батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу мэдээллийг цаг тухай бүр мэдээлэн ажиллаж байна.

/Хүснэгтээр харуулбал/

№	Шилэн дансны мэдээллийн төрлийн нэр	Мэдээлэл оруулах давтамж	Нийт мэдээлэх	Хугацаандаа мэдээлсэн	Мөнгөн дүн	Шийдвэр/гүй лгээний тоо
1	Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	Бүтэн жил	1	1	-	
2	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	Сар бүр	6	6	-	

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

3	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	Тухай бүр	6	6		15
4	Дараа жилийн төсвийн төсөл	Бүтэн жил	1	0	-	
5	Санхүүгийн тайлан	Бүтэн жил	1	0	-	
6	Санхүүгийн тайлан	Хагас жил	1	0	-	
7	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	Бүтэн жил	1	0	-	
8	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	Тухай бүр	6	6		0
9	Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт	Тухай бүр	6	6	-	
10	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	Тухай бүр	6	6	-	
11	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт	Улирал бүр	2	2		0
12	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	Тухай бүр	6	6	-	
13	Худалдан авах ажиллагааны тайлан	Бүтэн жил	1	1		0
14	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	Бүтэн жил	1	1	Төсөвт өртөг: 0	0
15	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл	Тухай бүр	6	6	Батлагдсан төсөвт өртөг: 0 Гэрээний дүн: 0	0
16	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ	Тухай бүр	6	6	Орлого: 3,443,284,877.75 Зарлага: 2,808,708,047.44	118

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын 2020 оны жилийн эцсийн тайлан, 2021 оны 1-р улирлын тайлан балансыг тус тус Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу хуулийн хугацаанд гаргасан.

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэж холбогдох судалгаа тайлан мэдээ, материалыг цаг хугацаанд нь гарган ажиллалаа.

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 452 тоот албан бичгээр “Зөрчилгүй санал дүгнэлт”-тэй авсан.

2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтээр өгсөн зөвлөмж, актын биелэлтийг хангах төлөвлөгөөг газрын даргаар батлуулж биелэлтийг нь гарган Нийслэлийн дэх Төрийн аудитын газар болон Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/10 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, зардлын хуваарийг сар, улирлаар гарган Санхүү төрийн сангийн хэлтсээр батлуулан мөрдөн ажиллаж байна.

Тус газар нь 2021 оны Орон нутгийн төсвөөс 1 389 352 400 /нэг тэрбум гурван зуун наян есөн сая гурван зуун тавин хоёр мянга дөрвөн зуун/ төгрөгийн санхүүжилт, Үйл ажиллагааны орлогоос 357 165 600 /гурван тавин долоон сая нэг зуун жаран таван мянга зургаан зуун/ төгрөгийн санхүүжилт нийт 1 746 518 000/нэг тэрбум долоон зуун дөчин зургаан сая таван зуун арван найман мянган/ төгрөгийн төсөв батлагдсан.


Батлагдсан төсвийн зардлыг эдийн засгийн ангиллаар нь 2020-2021 оныг харьцуулбал:

№	Эдийн засгийн ангилал	2020 он		2021 он	
		Батлагдсан төсөв	Хувиар	Батлагдсан төсөв	Хувиар
1	Цалин хөлс нэмэгдэл урамшуулал	1,002,048.70	57%	1,002,048.70	57%
2	Нийгмийн даатгал	135,276.60	8%	135,276.60	8%
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,536.90	3%	47,536.90	3%
4	Хангамжийн материал	44,453.90	3%	46,887.90	3%
5	Эд хогшил, урсгал засвар	3,500.00	0%	0.00	0%
6	Томилолт	500.00	0%	0.00	0%
7	БГАҮТХураамж	484,593.00	27%	480,925.30	28%
8	Бараа үйлчилгээний бусад зардал	7,100.00	0%	0.00	0%
9	Хичээл үйлдвэрлэлийн зардалд	7,200.00	0%	5,000.00	0%
10	Ажил олгогчоос олгох тэтгэмж	10,000.00	1%	10,000.00	1%
11	Тэтгэвэрт гаргахад олгох тэтгэмж	16,962.10	1%	18,842.60	1%
Нийт дүн		1,763,171.20		1,746,518.00	

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгууллагын зардлыг төлөвлөсөн төсвөөс хэтрүүлэхгүй хэмнэж ажилласны үндсэн дээр цалин хөлс, нийгмийн даатгал, бараа үйлчилгээний бусад зардал, Улсын мэдээллийн маягт хэвлэх зардлууд нийлээд 173 010 786.00 /нэг зуун далан гурван сая арван мянга долоон зуун наян зургаан/ төгрөгийг хэмнэсэн.

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

Төсвийн зардлын хэмнэлтийг 2021 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар харуулбал:



3.3.3. Түрээсийн гэрээ байгуулах, орлого төвлөрүүлэх ажлын хүрээнд:

Байгууллагын 2020.12.23-ны өдрийн 4/2117 дугаар албан бичгээр нийт 53 байгууллагад 2020 оны гэрээ дүгнэх, 2021 онд гэрээ цуцлах, шинээр байгуулах судалгааг ирүүлэхийг мэдэгдсэний дагуу холбогдох байгууллагуудаас түрээсийн гэрээ байгуулах санал ирүүлсэн. Түрээслэгч байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу холбогдох журмыг үндэслэн нийт 241 түрээсийн гэрээг шинээр байгуулан ажилласан байна.

- Шууд түрээс -6 (талбай 1433м², 147,742,000 төг),
- Дам түрээс -118 (талбай 5778,8м², 901,578,236 төг, нийслэлийн төсөв 60%-524,130,891 төг),
- Сургуулийн цайны Газрын түрээс -117 ("Үдийн цай" хөтөлбөр хэрэгжүүлж буй 109, ахлах сургуулийн цайны газрын 8, талбай 11,128.0м², 1,125,773,715 төг, нийслэлийн төсөв 60%- 675,464,229 төг)



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

- Цуцалсан түрээсийн гэрээ - 22 (талбай 617,4м², 97,952,160 төгрөг, нийслэлийн төсөв 60%- 58,771,296 төгрөг),
- Шинээр байгуулсан түрээсийн гэрээ - 19 (талбай 384,56м² 46,690,680 төгрөг, нийслэлийн төсөв 60%- 28,014,408 төгрөг)
- Нийслэлийн төр захиргааны 4-р байрны 20 түрээсийн гэрээний төслийг боловсруулж батлуулсан.
- Газрын даргын баталгаажуулсан шууд 8, дам 106 түрээсийн гэрээг кодлон, программд оруулан бүртгэлжүүлсэн.

Эхний хагас жилийн байдлаар Нийслэлийн төсөвт 727,7 сая төгрөг төвлөрүүлсэн, төлөвлөгөөний биелэлт 74%-тай байна. Хорио цээрийн дэглэмийн үеийн түрээсийн төлбөрөөс чөлөөлөх хүсэлтийг түрээслэгчид удаа дараа гаргасны дагуу төлбөрөөс чөлөөлөх асуудлыг судлан танилцуулж, Нийслэлийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар захирамжаар сургуулийн цайны газрыг 505.4 сая төгрөг, шууд түрээсийн 22.4 сая төгрөг, бусад дам түрээсийн 69.2 сая төгрөг чөлөөлсөн.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Шинэ коронавирусийн эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоолоор бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвийн үйл ажиллагааг бүрэн холбогдуулан сургуулийн Үдийн цай хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдээс төвлөрөх орлого буурсан, Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Урт цагаан үйлчилгээний төвийн үйл ажиллагааг зогсоох тухай” А/216 дугаар захирамжаар тус төвд үйл ажиллагаа явуулдаг 30 гаруй шууд түрээслэгчдээс орох орлого төвлөрөх боломжгүй болсон, Соёлын төв өргөөд түрээслэгчдээс орох орлогыг Соёлын төв өргөө өөрийн үйл ажиллагаанд зарцуулж төсөвт төвлөрүүлээгүйгээс түрээсийн орлого 350,5 сая төгрөгөөр буюу 13.0%-иар тасарсан, Нийслэлийн Орон сууцны корпорацийг татан буулгаж Төрийн орон сууцны корпорацтай нэгтгэх болсноор түрээсийн орлогын төлөвлөгөө биелэх боломжгүй болж байна.

Нийслэлийн өмчийн барилга байгууламжид Түрээслэгчийг сонгон шалгаруулах ажлын хүрээнд:

- Газрын даргын 2021 оны А/91 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсэг Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв-2, А/46 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг Цагдаагийн 2-р хэлтсийн цайны газрын сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан, Ерөнхий боловсролын 16 сургууль, Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвийн эмийн сангийн сонгон шалгаруулах комиссод орж ажилласан.
- Чингэлтэй дүүргийн 149 дүгээр сургуулийн “Үдийн хоол” хөтөлбөрийг хэрэгжүүлэгч цайны газрын түрээслэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэгт орж ажилласан ба материал ирүүлсэн аж ахуйн нэгж нь сонгон шалгаруулалтын шаардлага хангаагүй тул түрээслэгчийг сонгон шалгаруулаагүй болно.

3.3.4. Урт цагаан үйлчилгээний төвийн талаар:

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах нийслэлийн өмчийн 3 дугаар байр буюу Урт цагаан үйлчилгээний төв нь 1958 онд баригдаж ашиглалтад орсон нийт 7912,8 м² бүхий талбайтай 12 блокоос бүрдсэн барилга бөгөөд 2009, 2011, 2014 оны мэргэжлийн байгууллагуудын удаа дараагийн дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсоор ирсэн.

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР



Стандартын шаардлага хангахгүй тус төвийн үйл ажиллагааг зогсоох тухай Нийслэлийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/216 дугаар захирамж гарч үйл ажиллагааг нь бүрэн зогсоосон боловч “Урт цагаан шинэ эхлэл” ТББ нь Цахилгаан түгээх сүлжээ газартай гэрээ байгуулан 200 гаруй дам түрээслэгч, 11 корпуст үйл ажиллагаагаа явуулсаар байна. Тус төвд түрээсийн гэрээгээр үйл ажиллагаа явуулж байсан “Алаг даага” ХХК нарын 9 аж ахуй нэгж нь “Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх”-д нийслэлийн Засаг даргын А/216 дугаартай “Урт цагаан үйлчилгээний төвийн үйл ажиллагааг зогсоох тухай” захирамжийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг гаргасан бөгөөд энэ асуудал шүүхийн шатанд хянагдаж эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.

“Урт цагаан үйлчилгээний төв”-ийн түрээслэгч нарыг ажлын байраар хангах зорилгоор тус төвийн түрээслэгчдийн үйлдвэрчний эвлэлийн хороотой харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулан Нийслэлийн төр захиргааны 4 дүгээр байр буюу Улаанбаатар шилэн банкны 1 болон 2 давхарт түрээслэгчийг шилжүүлэн оруулсан.

1 дүгээр давхарт: 12 павильон бүхий 78.4 м² талбайтай, 12 түрээслэгч гэрээ байгуулсан.

2 дугаар давхарт: 34 павильон бүхий 313.1 м² талбайтай, 42 түрээслэгчийн гэрээ байгуулахаас 18 түрээслэгч гэрээ байгуулсан. Мөн тус давхрын 130м² талбайд 1,656 сая төгрөгийн засвар үйлчилгээг хийж тохижуулсан болно.

2020 оны 04-10 дугаар сарын түрээсийн төлбөрийн үлдэгдэл болох /3,966,405/ төгрөгийг барагдуулахаар түрээслэгчдэд мэдэгдэл хүргүүлэн ажиллаж байна. “КОВИД-19” цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан түрээсийн орлого бүрдүүлэхэд хүндрэл учраад байна.



3.3.5. Захиалагчийн хяналт тавьж ажилласан ажлын талаар:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу 2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт 2 захирамжаар 404,6 сая төгрөгийн өртөг бүхий 2 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллан, санхүүжилтийг олгосон байна.

- 2021.03.22 А/193 захирамжийн Цэвэр усны тусгай зориулалтын авто машин худалдан авах” НХААГ/202103294 дугаартай гэрээг /125,000.000 төгрөгийн/ “Нанопланет” ХХК-тай байгуулсан. Нийлүүлэгч компаниас хөрөнгө нийлүүлэх хугацааг хүлээж байна.
- Нийслэлийн Засаг даргын 2021.01.29-ний өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/40 дүгээр захирамжаар “Усан спорт, боулингийн төвийн техникийн шинэчлэл /БНД/ бараа, нийлүүлэх” НХААГ/202112163 дугаартай гэрээг /149,600.000 төгрөгийн/ “Эм

Си Ти” ХХК-тай байгуулсан. Нийлүүлэгч компаниас хөрөнгө нийлүүлэх хугацааг хүлээж байна.

3.3.6. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн талаар:

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар нь Газрын дарга, Орлогч дарга-2, Нэгжийн дарга-4, ахлах мэргэжилтэн-5, төрийн захиргааны албан тушаалын ангилалд–38 /үүнээс: албан хаагч түр орлон гүйцэтгэгч-2/, төрийн үйлчилгээний албан тушаалын ангилалд-27, гэрээт ажилтан–2 гэсэн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

- Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлагын систем” нь цалин хөлсний төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтыг сайжруулах, төсвийн байгууллагуудын төсөв бэлтгэх ажлыг автоматжуулах, албан хаагчдын цалин хөлстэй холбоотой бүх төрлийн мэдээлэл автоматаар илгээгдэх зэрэг зорилгоор шинэчлэгдэн баяжуулагдаж, улсын хэмжээнд нэгдсэн мэдээллийн сантай болох болсонтой холбогдуулан Төрийн албаны цалингийн нэгдсэн систем/ТАЦНС/-д албан хаагчдын мэдээллийг тогтмол шинэчлэн оруулсан.
- Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу нийт албан хаагчдын төрийн албан хаагчийн анкет болон шаардлагатай бусад материалыг шинэчлэн бүрдүүлсэн.
- НӨАУГ-ын даргын “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах” талаар, “Сахилга хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай” 2 удаагийн албан даалгаврын төслийг боловсруулан батлуулсан.
- Байгууллага, хэлтсийн чиг үүрэг, албан хаагчдын ажлын ачаалал, ажил үүргийн хуваарьт ӨМХАХ-ийн ахлах мэргэжилтэнтэй хамтран дүн шинжилгээ хийж, “Хүний нөөцийн төлөвлөлт нь байгууллагын өөрчлөлт хөгжлийн зорилт” илтгэх хуудсаар удирдлагуудад танилцуулсан.
- “Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын хөдөлмөрийн дотоод журам”, төрийн үйлчилгээний албан хаагчидтай байгуулах хөдөлмөрийн гэрээний загварыг шинэчлэн боловсруулж, удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, газрын даргын А/85, А/126 дугаар тушаалуудаар тус тус батлууллаа.
- Энэ хугацаанд нийт албан хаагчид ажиллагсадтай холбогдолтой 15 өргөдөл, хүсэлт хүлээн авч судлан, газрын даргын хүний нөөцийн чиглэлийн “Б” тушаалын 44 төсөл, “А” тушаалын 12 төслийг боловсруулж батлуулсан. Үүнд:
 - Ажлаас чөлөөлөх тухай- 12
 - Ажилд томилох тухай – 16
 - Тэтгэмж олгох тухай- 4 /4 хүнд/ 1 100 000 төгрөгийн
 - Шилжүүлэн ажиллуулах тухай- 3
 - Сахилгын шийтгэл ногдуулах тухай-4
 - Бусад-5

Ажлын үр бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд ажлын цаг ашиглалтад хяналт тавьж, эмнэлгийн чөлөөтэй -6 /листээр/, захиргааны чөлөөтэй –18 албан хаагчийн чөлөө олгох бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлж, сар бүрийн эцэст албан хаагчдын хоцролт, таслалтын мэдээг минутаар гарган орлогч дарга, хэлтсийн дарга нарт танилцуулсан.

НЗДТГ, НТАЗСЗ, холбогдох бусад байгууллагуудад дараах мэдээ, судалгаануудыг гаргаж хүргүүллээ. Үүнд:

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

- ✓ Удирдах албан тушаалтнуудын судалгаа
- ✓ Ёс зүйн зөвлөлийн мэдээлэл
- ✓ Худалдан авах ажиллагааны АЗ сертификаттай албан хаагчдын судалгаа
- ✓ 0-6, 0-12 насны хүүхэдтэй эхчүүдийн судалгаа
- ✓ 20-иос дээш жил ажилласан албан хаагчдын судалгаа
- ✓ Бүтэц орон тооны судалгаа
- ✓ Албан тушаалын ангиллын судалгаа
- ✓ Албан хаагчдын хаягийн судалгаа
- ✓ Төрийн албан хаагчийн нөөцийн судалгаа
- ✓ Сул орон тооны судалгаа
- ✓ Тангараг өргөсөн албан хаагчдын судалгаа
- ✓ Төрийн албаны тухай хууль тогтоомжийн нөлөөллийн судалгаа
- ✓ Төрийн албаны нэгдсэн тоо бүртгэлийн 25 төрлийн судалгаа, мэдээлэл
- ✓ Жендерийн судалгаа
- ✓ Соён гэгээрүүлэх ажил, нөлөөллийн судалгаа
- ✓ Албан хаагчдын вакцинжуулалтын судалгаа

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын 2021-2024 оны "Хүний нөөцийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

"НӨАУГ-ын 2021 оны сургалтын төлөвлөгөө"-нд 11 ажил, арга хэмжээ төлөвлөн батлуулж, төлөвлөгөөт сургалтуудад захиалга өгөн ажиллаж байна.

"НӨАУГ-ын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2021 оны төлөвлөгөө"-нд 12 ажил, арга хэмжээ хэрэгжүүлэхээр боловсруулан батлуулсан.

- Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолын дагуу 9 төрийн жинхэнэ албан хаагчид албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох саналыг Нийслэлийн Төрийн Албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлснээс 4 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан олгуулах, 1 албан хаагчийн зэрэг дэвийг шинээр олгуулах шийдвэр гарч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
- Газрын даргын 2021 оны А/30, А/159 дүгээр тушаалуудаар ээлжийн амралтын хуваарийг албан хаагчдын санал, ажлын шаардлагад нийцүүлэн батлууллаа.
- Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу ар гэрт нь гачигдал тохиолдсон 4 албан хаагчид нийт 1 100 000 төгрөгийн тэтгэмжийг олгосон.
- НӨАУГ-ын 30 жилийн ойг тохиолдуулан 2020 оны ажлын гүйцэтгэл, үр дүнгээр хүлээсэн үүргээ хамгийн сайн биелүүлсэн шилдэг ажилтан, шилдэг менежерийг хамт олны саналаар тодруулж, урамшуулал олгох тухай газрын даргын тушаал батлуулсан.
- НӨАУГ үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойг угтан 16 албан хаагчийг төрийн одон медальд тодорхойлсноос 2 албан хаагч "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон"-гоор, 1 албан хаагч "Алтан гадас" одонгоор шагнагдсан.
- Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хүүхдийн баярыг тохиолдуулан албан хаагчдын 16 хүртэлх насны хүүхдийн судалгааг шинэчлэн гаргаж, нийт 72 хүүхдэд 2 304 000 төгрөгийн бэлэг өгөх газрын даргын шийдвэрийг батлуулан хэрэгжүүлсэн.

Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангах талаар:

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэст байгууллагын төрийн захиргаа, төрийн үйлчилгээний албан тушаалтнуудаас хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудын нэрсийн жагсаалтыг хүргүүлж, хуулийн үйлчлэлд хамаарах ТЗ-6-аас дээш ангиллын албан хаагчдаас 2020 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг/2020/-ийг баталгааны хуудсаар хүлээн авч, мэдээ тайланг холбогдох байгууллагад хугацаанд нь тайлагнасан.


5 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг холбогдох материалын хамт АТГ-т хүргүүлэн хянуулж, мэдээллийг цахим www.meduuleg.iaac.mn/-д оруулан бүртгэсэн.

- “НӨАУГ-ын Авлигын эсрэг төлөвлөгөө”-г боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
- Газрын даргын 2021 оны А/129 дүгээр тушаалаар Байгууллагын Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэн батлуулж, Ёс зүйн зөвлөлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан.



3.3.7. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/-ээр үнэлсэн талаар

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийн 2020 оны баримтуудыг холбогдох хэлтсээс авч 2016-2020 оны харьцуулалтын дүн шинжилгээ хийж удирдлагад танилцуулсан. Үүнд:

- Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх 4 орлогын дүн шинжилгээ,
- Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын орлого, зардал, ашиг алдагдлын дүн шинжилгээ,
- ЭБХХХК-ын хурлаар шийдвэрлүүлсэн нийт хөрөнгийн дүн шинжилгээ,
- Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр бүртгэх, балансаас балансад шилжүүлэх барилга байгууламж, тээврийн хэрэгслийн дүн шинжилгээ
- Ковидын цар тахлын улмаас 2019-2020 оны “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний биелэлт дүгнэгдээгүй тул дүн шинжилгээ хийгдээгүй болно.





ӨМЧ ХУВЬЧЛАЛЫН ОРЛОГО



2020 оны сүүлчийн байдлыг авч үзвэл ашиг орлогын харьцуулалт нь 20,751,300.0 тэмдэгтээр өсөж байгаа ба 5 сарын өргөтгөл хийсний "өмч хувиараа оруулах" хэргийн үрэлт бүгд 37,591.3 хэмээх өөрчлөлт оруулжээ.

2019-2020	өсөх дүн	20,515,440.5	11,328.6%
2017-2020	өсөх дүн	15,875,187.1	11.1%
2018-2020	өсөх дүн	12,121,902.8	141.1%
2019-2020	өсөх дүн	20,398,744.1	6,178.9%


НОГДОЛ АШГИЙН ОРЛОГО



2019 оны сүүлчийн байдлыг авч үзвэл ашиг орлогын харьцуулалт нь 943,290.0 тэмдэгтээр өсөж байгаа ба 11 сарын өргөтгөл хийсний "өмч хувиараа оруулах" хэргийн үрэлт бүгд 301,1 хэмээх өөрчлөлт оруулжээ.

2019-2020	Өргөтгөл дүн	208,140,500.0	10.4%
2017-2020	Өргөтгөл дүн	188,702.0	0.0%
2018-2020	Өргөтгөл дүн	433,379.3	48.0%
2019-2020	Өргөтгөл дүн	147,852.20	15.6%



АКТЛАГДСАН ХӨРӨНГИЙН ОРЛОГО



2020 он 9 сарын 30-ны байдлаар эдийн засагчид 275 байгууллагын 21,327,513.2 тивийн өртөгний хөрөнгийн орлогог шилжүүлж авчээ. Энэ нь 2019 оны тусламжтайгаар 10,610,864.3 тивийн өртөгөөр буцаж 201.7% нь өсөж байгааг харахад болгох зарлагын дүн 12,581.7 тивийн өртөг болж 7.8%-аар буурагдсан байна.



2016-2020	Бүтээгдсэн дүн	11,684,300.0	-7.3%
2017-2020	Бүтээгдсэн дүн	13,335.7	-2.7%
2018-2020	Бүтээгдсэн дүн	195,780.6	-39.3%
2019-2020	Бүтээгдсэн дүн	12,581.7	-7.3%

БҮРТГҮҮЛСЭН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ДҮН





2016-2020	өсөөн дүн	16,871,094.8	15%
2017-2020	өсөөн дүн	65,476,193.4	78%
2018-2020	өсөөн дүн	171,073,700.5	512%
2019-2020	өсөөн дүн	101,626,576.2	165%

БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛСЭН
БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ



2016-2020	Бүхэлдэй дүн	133,403,643	-92.3%
2017-2020	Бүхэлдэй дүн	2,437,005	33.6%
2018-2020	Бүхэлдэй дүн	13,038,777	2063.6%
2019-2020	Бүхэлдэй дүн	6,377,455	158.6%

БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛСЭН
БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ




2016-2020	Бүхэлдэй дүн	133,403,643	-92.3%
2017-2020	Бүхэлдэй дүн	2,437,005	33.6%
2018-2020	Бүхэлдэй дүн	13,038,777	2063.6%
2019-2020	Бүхэлдэй дүн	6,377,455	158.6%


ЭБХХК-ЫН ХӨРӨНГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ДҮН




НӨҮГ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЗОРИЛТ



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ



БАЙГУУЛЛАГЫН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ:

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ

4.1. Байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах, иргэдэд үзүүлэх үйлчилгээг хөнгөн шуурхай болгох стратегийн зорилтын хүрээнд:

Нийслэлийн Өмчийн харилцааны талаарх мэдээ мэдээллийг түгээх, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээ мэдээлэл хүргэх, үйл ажиллагааг зохицуулах зорилгын хүрээнд МУ-ын хууль Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоол “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам”, Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоол “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийг байгууллагын цахим хуудасны үйл ажиллагаанд мөрдлөг болгон үндсэн үйл ажиллагаатай холбоотой болон цаг үеийн шаардлагаар зохион байгуулагдаж буй ажлуудын талаарх мэдээллийг байршуулан ажиллаж байна.

Байгууллагын веб-сайтад олон нийтэд нээлттэй ил тодоор дараах мэдээллүүдийг байршуулсан.

Үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хангах ажлын хүрээнд:

- ❖ Байгууллагын дүрэм
- ❖ Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм
- ❖ Хөдөлмөрийн дотоод журам

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

❖ Газрын даргын тушаалаар батлагдсан дотооддоо дагаж мөрдөж буй дүрэм журмууд

- ❖ Үйл ажиллагааны тайлан
- ❖ Төрийн үйлчилгээ өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтний мэдээлэл
- ❖ Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ /хагас жилийн байдлаар/
- ❖ Албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээ / хагас жилийн байдлаар /
- ❖ Албан хаагчидтай холбогдох утасны жагсаалт албан и-мэйл хаягийг тогтмол шинэчлэх.
- ❖ Үндсэн үйл ажиллагаатай холбогдон гарсан газрын даргын 151 тушаал
- ❖ Үндсэн үйл ажиллагаатай холбогдон гарсан НИТХТ-ийн 23 тогтоол

Хүний нөөцийн ил тод байдлын хүрээнд:

- ❖ 2017-2021 оны хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр
- ❖ Албан тушаалын тодорхойлолт
- ❖ Байгууллагын зардлаар суралцагчдын мэдээлэл
- ❖ 2021 онд шинээр ажилд томилогдсон албан хаагчдын мэдээлэл
- ❖ УЗ, ТУЗ-д өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй албан хаагчдын мэдээлэл

Төсөв санхүүгийн ил тод байдлын хүрээнд:

- ❖ 2020 оны төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээ/сар бүрээр/
- ❖ Санхүүгийн тайлан /2020 оны тайлан/

Цаг үеийн мэдээллийн хүрээнд:

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээллүүдийг тухай бүр хамтын гэрээтэй хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан сурталчлан, байгууллагын веб-сайтад байршуулж байна.

- Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газраас өмч эзэмшигч 756 байгууллагатай цахим зөвлөгөөн хийлээ.
- Нийслэлийн өмчийн томоохон барилга байгууламжийн үнэ цэнийг шинэчлэн тогтооно.
- Нийслэлийн өмчийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын ажлыг эрчимжүүлж эхэлжээ.
- ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны менежментийг сайжруулахад анхаарна.

Улс, нийслэлийн онцгой комиссын шийдвэр, Эрүүл мэндийн газрын мэдээллийг тухай бүр албан хаагчдад хүргэж, Коронавирус /КОВИД-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор 39 зурагт хуудсыг бэлтгэн олон нийтэд хүргэж сурталчилсан.



Хандалт:

- ❖ www.umch.ub.gov.mn. - 5218
- ❖ НӨАУГ [facebook](#) пэйж хуудас - 3975
- ❖ Байгууллагын [SKYPE](#) дотоод сүлжээнд – 53 хүнд тус тус хүргэж ажилласан.

4.3. Хяналт шалгалтын ажлын талаар:

- 2021 оны хяналт шалгалтын ажлын 12 ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Ковид-19 цар тахалтай холбоотой Засгийн газар, УОК, НОК-ын шийдвэрээр бүх нийтийн хөл хорио тогтоож зарим байгууллагын үйл ажиллагаа бүрэн зогссон учир хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөний хэрэгжилтэд туссан түрээсийн үйл ажиллагаатай холбоотой ажил хойшлогдоод байна.
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хүний эрхийн үндэсний комиссоос ирүүлсэн Урт цагаан үйлчилгээний төвтэй холбоотой хүсэлтийг судалж хариуг Нийслэлийн Засаг даргаар уламжлуулан хүргэсэн. Мөн Мэргэжлийн хяналтын газар, Урт цагаан хөгжлийн холбоо ТББ, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооноос ирсэн албан бичгийг судалж холбогдох хариуг тухай бүр хүргэсэн.
- Газрын даргын 2020 оны А/497 дугаар тушаалаар батлагдсан “Нуман цагаан” ХХК-ийн өргөдлийг хянаж, цаашид авах арга хэмжээний талаар санал дүгнэлтийг танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг 2021.01.26-ны өдөр хуралдаж, хуралдаанаас Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газар, Нийслэлийн Авто замын газарт тус барилга, газартай холбоотой баримт материалыг татах, тайлбар авахаар албан бичиг хүргүүлэхээр шийдвэрлэсэн. Ажлын хэсгийн хурлын дүгнэлтийг НИТХ-ын ажлын албанд 2021.05.19-ний өдрийн 4/607 дугаар албан бичгээр хүргүүлсэн.
- Газрын даргын 2021.01.12-ны өдрийн А/02 дугаар тушаалаар Нийслэлийн Соёлын төв өргөөний түрээсийн үйл ажиллагаа, барилга байгууламж, байр талбай болон эд хөрөнгийн хөдөлгөөн, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт, шалгалт хийх удирдамж батлуулсан. НСТӨ-ний барилгын “Г” корпусын 1-13 давхрын түрээсийн байранд хэмжилт хийн, иргэн аж ахуйн нэгжтэй байгуулсан түрээсийн гэрээний хэрэгжилт, төлбөрийн төвлөрүүлэлт, гэрээнд заасан зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд шалгалт хийн Илтгэх хуудсаар удирдлагад танилцуулж НСТӨ-нд зөвлөмжийг албан бичгээр хүргэсэн.
- НИТХТ-ийн 2014 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх журам”-ын дагуу түрээсийн гэрээний үүргээ биелүүлээгүй 4 иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад нийслэлийн өмчийн байр талбайг чөлөөлөх талаар мэдэгдэл өгөн, шаардлага тавьж, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулан удирдлагуудад танилцуулсан.
- Соёлын өвийн үндэсний төвийн Захиргаа удирдлагын газрын дарга н.Энхтунгалагтай нийслэлийн өмчийн байр талбайг чөлөөлөх талаар мэдэгдсэн.
- Өргөө амаржих газар, Орос Монголын хамтарсан 3-р сургууль, Баянгол дүүргийн Боловсролын хэлтэс, 19 сургууль, Хүүхдийн сувилал, Мөнх-Үжин ӨЭМТ, Ус сувгийн Удирдах газрын хүсэлтийн дагуу данснаас хасах хөрөнгийг газар дээр нь үзэж танилцсан.
- Юнивишн ХХК-ны ирүүлсэн гэрэлтүүлгийн шонгийн түрээсийн талаар хүсэлтийг судалж эзэмшигч байгууллага болох Хан-Уул дүүргийн ЗДТГ-т холбогдох саналыг ирүүлэх албан бичиг хүргэсэн.
- Нийслэлийн Засаг даргын 2008 оны 585 дугаар захирамжаар иргэн Ж.Эрдэнэцэгт дарааллын дагуу хуваарилсан орон сууцыг данснаас хасч хүлээлгэн өгөх талаар БГД-

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

ийн ЗДТГ-т албан бичиг хүргэсэн. Тус орон сууцны талаар НЗДТГ-т танилцуулгыг хүргэсэн болно.

4.4. Хууль шүүхийн байгууллагад төлөөлөх ажлын талаар:

Шүүхийн шатанд хянагдаж байгаа 25, нэмж оролцогчоор татагдсан 4 шүүхэд оролцож байна. Үүнд:

- Анхан шатны шүүх - 21,
- Давж заалдах шатны шүүх - 3,
- Хяналтын шатны шүүх-504

Улсын Дээд шүүхийн 2021 оны 03 дугаар сарын 9 оны тогтоолоор “Мичид энерги” ХХК-ны нэхэмжлэлийг хүчингүй болгосон.

4.5. Дотоод хяналт шалгалтын талаар:

Нийслэлийн өмчит байгууллагуудын актлагдсан хөрөнгийг татан төвлөрүүлэх, худалдан борлуулах зорилгоор Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2007 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн №142 дугаар тушаалаар байгуулагдсан Данснаас хасагдсан хөрөнгийн хөдөлгөөний төвийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж санал дүгнэлт гаргаж ажилласан. Дотоод хяналт шалгалтын дүгнэлтэд үндэслэн газрын даргын 2021.04.07-ны өдрийн А/51 дугаар тушаалаар тус төвийг татан буулгаж, эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай 83 тушаалын дагуу татан авалтыг гүйцэтгэж, худалдан борлуулж болох эд хөрөнгийг борлуулж, актлах эд хөрөнгийг акталж, устгах ажлыг зохион байгуулсан.

Данснаас хасагдсан хөрөнгийн хөдөлгөөний төвийн орлого, зардлын талаар:

Д/д	Он	Төлөвлөгөө	Орлого	Зардал		Нийт зардал	Зөрүү
				Цалин	Бусад		
1	2019	160.000.000	38.971.740	50.135.306,31	11.773.400	61.908.706,31	-22.936.966,31
2	2020	160.000.000	38.506.640	54.941.942,01	27.416.998	82.358.940,01	-43.852.300,01
3	2021	160.000.000	8.772.580	8.424.290,65	570.000	8.994.290,65	-221.710,65
	Нийт	480.000.000	86.250.960	113.501.538,97	39.760.398	153.261.936,97	-67.010.976,97

ДХХХТ-ийн албан хаагчдын хүсэлтийг харгалзан үзэж 2 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэлгийг байгууллагаас олгосон.

Цаашид тус төвийн үйл ажиллагаанд хамаарагдах актлагдсан барилгаас гарсан хоёрдогч түүхий эдийг худалдан борлуулах, тээврийн хэрэгслийн нээлттэй дуудлага худалдаа зохион байгуулах ажлыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар зохион байгуулаад явах боломжтой гэж үзсэн.

БУСАД АЖЛЫН ТАЛААР

5.1. Нийслэлийн төсөвт байгууллагууд, НӨҮГ-ууд болон бусад байгууллагуудад хийж хэрэгжүүлсэн ажил


2021 оны 01 дүгээр сарын 05-наас 06-ны өдрүүдэд Нийслэлийн өмчийг эзэмшигч, ашиглагч 756 байгууллагын удирдлагуудтай хийх уулзалт, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, ашиглалтын зардлыг бууруулж, санхүүгийн сахилга батыг сайжруулах,

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

үргүй зардлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлт хийх, өмч хөрөнгөд тавих хяналтыг сулруулахгүй байхад онцгой анхаарч ажиллах үүрэг чиглэлийг өгч холбогдох зөвлөгөө мэдээлэл, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилласан болно. Цахим зөвлөгөөнд Нийслэлийн 9 дүүргийн Төр, захиргааны байгууллага, Эрүүл мэндийн байгууллага, Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, Нийслэлийн болон дүүргийн ОНӨТҮГ, ОНӨААТҮГ, Нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой компаниудын удирдлага, дарга, захирлууд зэрэг 756 байгууллагын төлөөлөл 1003 албан тушаалтан хамрагдсан байна.




Нийслэлийн өмчийн томоохон барилга байгууламжууд болох үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор шинэчлэн тогтоох ажлын хүрээнд 2021 оны 02 дугаар сарын 19-ний өдөр Монголын мэргэшсэн үнэлгээний компанийн төлөөллийг оролцуулсан цахим уулзалтыг зохион байгуулсан. Тус уулзалтад “Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт”, “БДО аудит ХХК”, “Мөнх оргил трейд” ХХК, “Эрдэнэс экаунтинг энд консалтинг” ХХК, “Бэсгэ” ХХК, “Файн эстимейт” ХХК-иудын захирал, удирдлагууд оролцож нийслэлийн өмчийн томоохон барилга байгууламжуудад хөрөнгийн үнэлгээ хэрхэн хийх, өмчийн асуудал хариуцсан төрийн албан хаагчдыг хөрөнгийн үнэлгээгээр мэргэшүүлэх талаар хамтран ажиллахаар санал солилцсон. Уулзалтын үр дүнд байгууллагын 2 албан хаагч “Хөрөнгийн үнэлгээчнийг бэлтгэх анхан шатны 14 хоногийн сургалт”-д хамрагдан амжилттай төгсөж, гэрчилгээ авсан байна.



Нийслэлийн өмчит хуулийн этгээд болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын дүрмээр хүлээсэн чиг үүрэг, төсвийн хэмнэлтийн горим, хөдөлмөр хамгааллын аюулгүй байдлыг эрчимжүүлэх, Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах чиглэлээр гарсан шийдвэрийг цаг алдалгүй шуурхай хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/14 дүгээр захирамжаар зөвлөн туслах үүрэг бүхий

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

ажлын хэсэг байгуулагдан 05 дугаар сарын 17-ны өдрөөс 05 дугаар сарын 28-ны өдрийн хооронд орон нутгийн өмчит 20 үйлдвэрийн газарт очиж ажилласан.



ЗУРГААДУГААР БҮЛЭГ.

1. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АЖЛУУД

6.1.1. Иргэдийн өргөдөл, санал гомдлыг шийдвэрлэх:

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт 2021 оны эхний хагас жилийн байдлаар 84 өргөдөл, гомдол албан хаагчид болон иргэд, ААН-ээс бичгээр ирүүлснийг хүлээн авч "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль"-ийн дагуу шийдвэрлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. Нийт 84 санал хүсэлт, өргөдөл гомдол ирсний 73 өргөдлийг шийдвэрлэсэн. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7 хоног 14 цаг 46 минут, өргөдөл гомдлын индексийн үзүүлэлт "В" үнэлгээтэй байна. Шийдвэрлэх шатандаа судлагдаж байгаа хүсэлт, өргөдөл 11, хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн өргөдөл байхгүй.

Хүсэлт


- Түрээсийн гэрээ, түрээсийн төлбөртэй холбоотой 33
- Тээврийн хэрэгслийн дуудлага худалдаатай холбоотой 12,
- Архивын лавлагаа, мэдээлэл хүссэн 6
- Тэтгэвэр тэтгэмж, тусламж олгох, ажлаас чөлөө хүсэх, ажлаас чөлөөлөгдөх зэрэг хүний нөөцтэй холбоотой 16
- Бусад 17

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал:

Д/Д	Хэлтэс	Шийдвэрлэлт			Нийт	Шийдвэрлэлтийн хувь
		Шийдвэрлэгдсэн	Судлагдаж байгаа	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн.		
1	Удирдлага	1	2	-	3	33,3%
2	Захиргаа санхүүгийн хэлтэс	32	6	-	38	84,2%
3	Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтэс	2	-	-	2	100%
4	Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс	2	-	-	2	100%
5	Өмчийн мэдээлэл хяналт, ашиглалтын хэлтэс	36	3	-	39	92,3%
	Нийт	73	11	-	84	87%

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг сүүлийн 2 жилийн мөн үетэй харьцуулбал:




Өргөдөл гомдолд хариу өгсөн хэлбэр:

Хариу өгсөн хэлбэр		
Программ+мессэж	Программ+мессеж+утсаар	Программ+мессеж+албан бичиг
28	11	34

Өргөдөл гомдол шийдвэрлэсэн байдлын тайлан:

Ангилал		
Иргэний талд шийдвэрлэсэн	Боломжгүй тухай хариу өгсөн	Бусад
44	14	15

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацаа



Зөрчлийн тоон үзүүлэлт

Д/д	Зөрчлийн төрөл	2020 он	2021 он
1	Өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил	1	3
2	Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчлийн тоо	21	5
3	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил	49	24
Зөрчлийн тоо		71	32


НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

Тодорхой арга хэмжээг авч ажилласны үр дүнд зөрчлийн үзүүлэлт өмнөх оноос 54%-иар багассан байна. (2020 эхний хагас жилд 71 байсан бол 2021 оны мөн үед 32 (55%) болж багассан байна.

6.1.2. Ирсэн, явсан бичгийн бүртгэл, хяналтын ажлын талаар:

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын EDOC программд 2021 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар нийт 1614 албан бичиг ирж бүртгэгдсэний дагуу хариу өгч хугацаанд нь шийдвэрлэсэн-1529 албан бичиг, судлагдаж байгаа -85 албан бичиг, хугацаа дөхсөн -14, хугацаа сунгуулсан -24 албан бичиг байна. Албан бичгийн шийдвэрлэлт 97%-тай байна.

Албан бичгийн шийдвэрлэлтийг графикаар харуулбал:



Нийт албан хаагчдад 14 хоног тутам шийдвэрлэх хугацаа дөхсөн болон хугацаа хэтэрсэн албан бичгийн жагсаалт гарган танилцуулах хуудсаар танилцуулан, гарын үсэг зуруулан хугацаандаа шийдвэрлэхийг мэдэгдэж байна.

Тайлант хугацаанд нийт 613 ширхэг албан бичигт дугаар өгч, edoc программаар бүртгэн холбогдох байгууллагуудад нь шилжүүлж, 87 албан бичгийг шуудангийн салбарт хүлээлгэн өгсөн.

6.1.3. Архивын ажлын талаар:

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын “Архивын баримт хүлээн авах тухай” 2021 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 02 дугаартай албан даалгавраар хуваарь гарган 2021.02.01-2021.02.25-ны хооронд албан хаагчдаас архивын хадгаламжийн нэгжүүдийг архивт хүлээн авсан.

- ❖ 70жил хадгалах-2 ХН
- ❖ Байнга хадгалах-120 ХН
- ❖ Түр хадгалах-100 Хн

Архивт хүлээн авсан хадгаламжийн нэгжүүдийг графикаар харуулбал:

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР



6.1.4. Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын тушаалын биелэлтийн талаар:

Тайлант хугацаанд газрын даргын нийт 163 тушаал гарснаас “А” буюу хөрөнгө бүртгэн авах, балансаас балансад шилжүүлэх, данснаас дансанд шилжүүлэх, данснаас хасах зэрэг үндсэн чиг үүргийн дагуу 163 тушаал, “Б” буюу хүний нөөцийн чиглэлээр 44 тушаал гарч 100%-ийн биелэлттэй байна.

№	Тушаалын нэр	Тоо	Биелэлт
А тушаал - 166			
1	Эргэлтийн бус хөрөнгө бүртгэх тухай	27	100%
2	Хөрөнгө данснаас хасах тухай	48	
3	Данснаас дансанд шилжүүлэх тухай	18	
4	Ажлын хэсэг байгуулах тухай	7	
5	Тээврийн хэрэгсэл данснаас хасах тухай	37	
6	Зардал гаргах тухай	8	
7	Бусад	18	
Б тушаал - 44			
8	Ажилд томилох тухай	14	100%
9	Ажлаас чөлөөлөх тухай	15	
10	Тэтгэмж олгох тухай	3	
11	Сэлгэн ажиллуулах тухай	1	
12	Шилжүүлэн ажиллуулах тухай	2	
13	Бусад	9	

6.2. Дотоод ажлын талаар:

Коронавирус “КОВИД-19” цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:

МУ-ын Засгийн газрын 2021 оны 01, 02, 27, 78 дугаар тогтоол, НЗД-ын 2021 оны А/25, А/87, А/161, А/221 А/246, А/265, А/313 дугаар захирамжийн дагуу “Халдвар

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

хамгаалал, хорио цээр, хязгаарлалт"-ын дэглэмийг баримтлан ажлын байранд ажиллах /5%-30%/ бусад албан хаагчдыг цахимаар ажиллуулж үйл ажиллагаагаа тасралтгүй хэвийн явуулж байна.

Цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагад хариуцлагатай жижүүрийг ажиллуулан ажлын байранд ирж ажиллаж байгаа албан хаагчдын биеийн халууныг өдөрт 2 удаа үзэх, хоорондын зайг 2 метрт барьж ажиллуулах, цэвэрлэгээ, агаар сэлгэлт, амны хаалт зүүсэн эсэхэд хяналт тавих, зайлшгүй шаардлагаар ирсэн иргэдийг байгууллагын QR кодыг уншуулж, бүртгэл хөтлөн, мэргэжилтэнийг дуудан хоорондын зайг барьж уулзуулах зэрэг халдвар хамгааллын дэглэмийг чанд сахин ажиллаж, мэдээллийн самбар, цахим хуудсанд зөвлөмж мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулан, иргэд олон нийтэд сурталчлан ажиллаж байна.

Байгууллагын нийт албан хаагчийн 96% нь Коронавируст халдвар (COVID-19)-ын вакцинжуулалтын 2 тунд бүрэн хамрагдсан.

Эмнэлгийн нөөц хангалтыг бүрдүүлэн 3 удаагийн татан авалтыг хийлээ.

- ✓ Нэг удаагийн амны хаалт- 3000 ширхэг
- ✓ Хамгаалалтын хувцас хэрэглэл -10 ширхэг
- ✓ Гар ариутгагч 12 мянган литр
- ✓ Ариутгал халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээний бодис /13 литр, 1 уусмалаар хайрцаг/
- ✓ Нэг удаагийн хамгаалалтын бээлий -18 хайрцаг
- ✓ Зайлшгүй үед хэрэглэгдэх эм тариа
PCR шинжилгээний түргэвчилсэн 40 ширхэг тест



Бүх нийтийн бэлэн байдлын үед ажиллах хуваарийн дагуу 2021 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 2 дугаар сарын 11-ний өдрийг хүртэлх хугацаанд "Хүчит Шонхор" худалдааны төвөөр үйлчлүүлж буй иргэдийн биеийн халууныг үзэж бүртгэх хөтлүүлэх, ОР уншуулж байгаа эсэхэд хяналт тавин, зөвлөгөө мэдээллийг хүргэж ажилласан. Тус газарт үүрэг гүйцэтгэж байх хугацаанд сар шинийн баяр болж байгаатай холбогдуулан, хүн амын хөдөлгөөн, нягтрал ихтэй байсан тул халдварын хамгааллын дэглэмийг сахиулан ажилласан ба мэдээллийг өдөр бүрийн 14:00 цаг НОБГ, НЗДТГ-т хүргүүлэн ажилласан.



Нийслэлийн Онцгой комиссын шийдвэрээр "Нэг өрх – Нэг иргэн" коронавирусийн илрүүлэг шинжилгээнд иргэдийг хамруулах аяны хүрээнд тус байгууллагын 24-48 насны эрэгтэй 21 албан хаагчид 02.23-ны өдрийг хүртэл хуваарийн дагуу БГД-ын 6, 7, 8 дугаар

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

хороонд эргүүлийн үүргийг гүйцэтгэн мэдээллийг 12:00, 16:00, 19:00 цагт холбогдох газарт хүргүүлэн ажилласан.



Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Өөрт хэрэггүй зүйлээ хэрэгтэй нэгэндээ өгцгөө" уриалга бүхий "Өгөөмөр нийслэлчүүд-2021" аянд байгууллагын албан хаагчид нэгдэж, идэвхтэй оролцлоо.



Цаашид авах арга хэмжээ:

- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, нийслэлийн ОНХС, замын сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнд шинээр бий болсон барилга, тээврийн хэрэгслүүдийг нийслэлийн өмчийн бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулан гүйцэтгэх;
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66, 67 дугаар тогтоолоор батлагдсан журмуудыг шинэчлэн боловсруулж, батлуулах талаар бусад хэлтэстэй хамтран ажиллах;
- Нийслэлийн Засаг даргын 2020 оны захирамжуудын дагуу гаргасан хөрөнгө оруулалтын ажлын судалгаан дээр үндэслэн хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээний техникийн баримт бичгийг татан авах ажлыг зохион байгуулах;
- Нийслэлийн өмчөөс хувьчлагдах эд хөрөнгийн жагсаалтад орж батлагдсан боловч өнөөдрийг хүртэл хувьчлагдаагүй, нийтэд зарлан мэдээлсэн ч хувьчилж авах хүсэлт сонирхсон этгээдээс ирээгүй хуулийн этгээд, барилга байгууламжууд дээр хэрэгжүүлэх төсөл, хөрөнгө оруулалтын талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдтэй хамтран судалж, санал боловсруулах;
- Нийслэлийн өмчит байгууллага, аж ахуй нэгжүүд, үйлдвэрийн газруудын эзэмшиж ашиглаж буй газрыг хамгаалах, бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлэх;

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

М.БАЯРАА /ГАЗРЫН ДАРГА/

Б.БОЛОР-ЭРДЭНЭ /ОРЛОГЧ ДАРГА/

Н.МӨНХБААТАР /ОРЛОГЧ ДАРГА/

Б.БАТБАЯР /ЗСХ-ИЙН ДАРГА/

Б.УУГАНЦЭЦЭГ /ЗСХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН/

ХЯНАСАН:

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: